



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/99

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн технологийн багш, ажилчдыг Буриад улсын Улан-Үдэ хотод зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, туршлага солилцох арга хэмжээнд оролцоход 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ